



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

### Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

1. "Чингис лэнд девелопмент групп-Шинэ хөгжлийн зам" ХХК-ийн нэхэмжлэлтэй, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга О.Одончимэг, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа нарыг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.1-д заасан хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн шаардлага, тайлбар, нотлох баримт, хэргийн материалтай танилцах, тэмдэглэл, хуулбар хийх, шүүх хуралдаанд оролцох, нотлох баримт гаргаж өгөх, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, бусад нотлох баримт цуглуулах, нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг хуульд заасан үндэслэлээр татгалзан гаргах хүсэлт гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчид асуулт тавих, мөн хуулийн 28.2-т заасан хариу тайлбар гаргах, нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах, өмгөөлөгч авах, шүүхийн шийдвэрийг давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах эрхийг олгосугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

